

# ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН НИЙЦЭЛ

---

Хяналт шалгалт, зохицуулалтын  
газар

Б.Долгорсүрэн

2020.9.17



# Агуулга

1. Хувьцаат компаниудын хуулиар хүлээсэн үүрэг
2. Хувьцаат компаниудад зайнаас тавих хяналт
3. Хувьцаат компаниудын газар дээрх хяналт шалгалт
4. Хариуцлага
5. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

## ХУУЛЬ ТОГТООМЖ:



- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай /2005/



- Компанийн тухай /2011/
- Үнэт цаасны зах зээлийн тухай /2013/



- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай /2009/



- Аудитын тухай /2015/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай /2015/




- Зөрчлийн тухай /2016/

## ХОРООНООС БАТАЛСАН ЖУРАМ, ТОГТООЛ:

- “Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам” /2003-12-09 № 65/
- “Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар” /2012-03-14 №74/
- “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам” /2014-05-07 №160/
- “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам” /2015.12.17/
- “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг шинэчлэн батлах тухай” /2018-12-14 № 377/
- “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам” /2020.09.09 № 880/
- “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” /2020.01.29 № 28/

## Хувьцаат компаниуд





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Үнэт цаасны зах зээлийн тухай  
*/Шинэчилсэн найруулга/*

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-ээс 20.1.10-т заасан Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Компанийн тухай  
*/Шинэчилсэн найруулга/*

- 46 дугаар зүйл.Ногдол ашиг хуваарилах**
- 47 дугаар зүйл.Ногдол ашиг хуваарилах нөхцөл**
- 48 дугаар зүйл.Компанийн эд хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хязгаарлалт**
- 57 дугаар зүйл.Компанийн хувьцааг худалдан авахыг хувьцаа эзэмшигчид санал болгох**
- 58 дугаар зүйл.Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан тухай мэдэгдэх**
- 59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал**
- 77 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох**
- 98 дугаар зүйл.Компанийн талаар мэдээлэл авах**

| Зүйл заалт | Компанийн тухай хууль /Товч утга/  | Тайлбар  |
|------------|--|--|
| 46.14      | Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргах...  | 2020 оны эхний хагас жилийн байдлаар нэр бүхий 31 ХК-аас ногдол ашиг тараах ТУЗ-ийн шийдвэрийг Хороонд ирүүлсэн.   |
| 57.1       | Хувьцаат компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор... | “Таван богд трейд” ХХК нь “Атар Өргөө” ХК-ийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсны дараа сайн дурын үндсэн дээр хувьцаа худалдан авах саналаа Хороонд ирүүлж Хороо өөрийн цахим хуудсаар мэдээлсэн.  |
| 57.8       | Санхүүгийн зохицуулах хороо компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигч болохоо нотолсон мэдэгдлийг үндэслэн тухайн хяналтын багц эзэмшигчээс энэ хуулийн 57.1-д заасны дагуу санал гаргахыг шаардах үүрэгтэй...  | Тухайн хувь хүн, хуулийн этгээд хувьцаат компанийн хяналтын багц эзэмшдэг болсон талаарх мэдээлийг ирүүлэхэд тухай бүр энэ хуулийн 57.1-д заасан бусад хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах санал гаргах үүрэгтэйг анхааруулж шаарддаг. |

|      |  |  |
|------|--|--|
| 58.1 | Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор.... | Хуулийн дагуу ирүүлсэн мэдээллийг Хороо бүртгэдэг.           |
| 77.4 | Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналыг тус тусад тоолно.  | Хорооны 2020.09.09-ний 880 дугаар тогтоолоор журам баталсан. |
| 98   | Хувьцаа эзэмшигчдэд компанийн талаарх баримт материал, мэдээллийг гаргаж өгөөгүй зөрчил  | “Ард даатгал” ХК,<br>“Адуунчулуун” ХК,<br>“Хорго хайрхан” ХК |

# Зайнаас тавих хяналт /СЗХ-д мэдээлэл ирүүлэх хуанли/

| № | Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл                           | Хууль, журмын заалт  | Хугацаа   |
|---|--|--|---|
| 1 | Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтэд зарлах огноо | Компанийн тухай хууль / "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын заалт     | Хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор        |
| 2 | Бүртгэлийн өдөр  |  | Нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр                    |
| 3 | Хурал хуралдуулах огноо                                    |  | Шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоног                      |
| 4 | Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр   |  | ХЭХ хуралдах шийдвэр гарсанаас хойш 5 хоногт                    |
| 5 | Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах өдөр, цаг           | Компанийн тухай хууль 59.4   | ГУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор |
| 6 | Хагас жилийн үйл ажиллагааны тайлан                        | Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам” | Жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор                   |
| 7 | Жилийн үйл ажиллагааны тайлан                              |  | Дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор                 |
| 8 | Хагас жилийн санхүүгийн тайлан                             | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3  | 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор                              |
| 9 | Жилийн санхүүгийн тайлан                                   |  | Дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор                    |

## Зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлж буй зарчмууд:

Нийт ХК-уудад жил бүрийн эхэнд тухайн жилд хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг өгөх;

1

Тухайн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, ногдол ашгийн хуваарилалттай холбоотой асуудлуудад хяналт тавих;

2

Хороонд ирүүлэх үүрэгтэй баримт материалыг цаг тухайд нь ирүүлж байгаад хяналт тавих, холбогдох анхааруулга хүргүүлэх;

3

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгохдоо Компанийн тухай хуульд заасныг баримталж байгаа эсэхэд хяналт тавих;

4



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Баян чөлрөө 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@fsc.mn, http://www.fsc.mn

2020.02.10 № 9/430  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Даалгавар өгөх тухай

Хорооноос 2020 онд үнэт цаасны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолооог бүрдүүлэх, үнэт цаас гаргагч буюу хувыцаат компанийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах бодлогыг баримталж байна.

Иймээс танай компани дараах хугацаатай даалгаврыг биелүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Компани нь хувыцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Хувыцаат компанийн хувыцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг хэрэгжүүлж ажиллах;

2. Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-д заасны дагуу тухай бүр болон тодорхой хугацаанд тайлагнах олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх;

3. "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" Хорооны 2020 оны 28 дугаар тогтоолд зааснаар зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох "ҮЦТХТ" ХХК-аар дамжуулан ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр хувыцаа эзэмшигчийн дансанд шууд байршуулах; / <http://www.fsc.gov.mn/legal/detail?id=6740>

4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө", СТОУС 16-ын 32-т "Зарим хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц, тогтмол өөрчлөлт гардаг бол тэдгээрийг жил бүр дахин үнэлэх шаардлагатай. Үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд гурванс таван жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой" гэж заасантай нийцүүлж танай компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд хөрөнгийн үнэлгээ хийлгээгүй бол Хороонд бүртгэлтэй үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх компаниар хөрөнгийн үнэлгээ хийлгэх асуудлыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн сонгож, 2020 оны хоёрдугаар улиралд багтаан хөрөнгийн үнэлгээ хийлгэж, холбогдох өөрчлөлтүүдийг санхүүгийн тайландаа тусгаж, дүгнэлтийг Хороонд 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлантай хамт ирүүлэх;

5. Хувыцаат компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрхтэй хуулийн этгээдээр компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэн 2020

НЭР БҮХИЙ 244 ХК-Д

оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороо болон хөрөнгийн биржид цаасаар ирүүлэх;

6. Хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг шинэчлэн баталж, хөрөнгийн биржийн "А" санбар дээр бүртгэлтэй хувыцаат компаниуд энэхүү кодекснийг хэрэгжүүлж ажиллах ба бусад хувыцаат компаниуд хэрэгжүүлж байгаа талаараа тайлагнаж ажиллахыг үүрэг болгосны дагуу танай компани "Компанийн засаглалын кодекс"-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тайлбар, холбогдох материалыг ирүүлэхийг мэдэгдье.

Дээр дурдсан хугацаатай даалгавар буюу ирүүлэхийг шаардсан тайлбар, баримт материалыг 2020 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор Хороонд ирүүлэх, түүнчлэн хувыцаат компани нь заавал өөрийн цахим хуудастай байх, цахим хуудасны үйл ажиллагааг нээжжүүлэх шаардлагатай байгааг анхааруулж байна.

Хэрэв компанийн хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах, хуралдуулах, хурлаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрүүд нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Хувыцаат компанийн хувыцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд Хорооноос танай компанийн хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин тогтоодор болсонд тооцох боломжгүй нөхцөл үүсэхийг анхааруулж байна.

Мөн Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй, түүнчлэн энэхүү албан бичгээр өгөгдсөн үүрэг даалгаврыг дурдсан хугацаанд Хороонд ирүүлэхгүй тохиолдолд танай компанитай холбоотой аливаа тодорхойлолтыг гаргаж өгөх боломжгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэхгүй, Компанийн тухай хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нийтэд болон эрх бүхий байгууллага, хувыцаа эзэмшигчдэд танилцуулах, мэдээлэх, тайлагнах, мэдэгдэх үүргээ биелүүлэхгүй хувыцаат компанийг Зөрчлийн тухай хуулийн 10.11 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлд тус тус заасан торгуулийн арга хэмжээ авах нөхцөл үүсэх тул аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг мэдэгдэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ДОЛГОРСҮРЭН



## ХК-иудад хүргүүлсэн албан бичгүүд /хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой/

2020 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн 9/470 тоот албан бичиг;


2020 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Ковид-19 корона вирус халдвар дэгдсэнтэй холбогдуулан гамшигаас хамгаалах өндөршүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан зөвлөмж, анхааруулга;

2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар;

2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хувьцаат компаниудын ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн талаар;

2020 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар;

2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1491 албан бичгийг, 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр Эрчим хүчний яамны сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандсан.




Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д “Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно” гэж заасан.


Нэр бүхий 63 ХК нь 2019 оны ХЭХ-аа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуралдуулаагүй тул ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит бусаар зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсон.

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7-д “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ энэ хуулийн 59.4-т заасан хугацааны дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээлнэ” гэж заасан.

Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал хийгээгүй ХК-ын тоо



## ХЭХ-ын мэдэгдэлтэй холбоотой сүүлийн 5 жилийн мэдээлэл



## УБАШ

2019 онд **9 ХК**-д газар дээр хийгдсэн шалгалтаар, 2020 онд 1 ХК-д хугацаатай үүрэг даалгавар бүхий **УБАШ** хүргүүлсэн.

## ХЭХ

**163 ХК**-аас **ХЭХ**-ын мэдэгдэл ирүүлсэнийг хянасан.

**134 ХК**-ийн **ХЭХ**-ын материалыг хянаж, албан бичгээр хариу хүргүүлсэн.


**ХЭХ**-аа зарлан хуралдуулаагүй **63 ХК**-д анхааруулга, мэдэгдэл хүргүүлсэн.

## Тайлан

2020 оны эхний хагас жилээр **96 ХК санхүүгийн тайлан, 47 ХК үйл ажиллагааны тайлан** ирүүлснийг хянаж, тайлангийн хариу хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн **аудитлагдсан санхүүгийн тайланг 126 ХК** ирүүлсэн.

Хувьцаат компанийн үйл ажиллагаанд  
хийсэн газар дээрх хяналт шалгалт



| Зөрчлийн хэргийн тоо |   |
|----------------------|---|
| 2018 он              | 2 |
| 2019 он              | 7 |
| 2020 он              | 2 |

| Торгуулын хэмжээ /сая төгрөг/ |      |
|-------------------------------|------|
| 2018 он                       | 20.0 |
| 2019 он                       | 93.0 |
| 2020 он                       | 7.0  |



- “А” компани нэгдсэн санхүүгийн тайлан гаргах үүргээ биелүүлээгүй учир **Зөрчлийн тухай хуулийн 10.11 дүгээр зүйлийн 2.2-т** зааснаар 20,000 нэгж
- “Б” компани хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ мэдээллээ нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй учир **Зөрчлийн тухай хуулийн 10.11 дүгээр зүйлийн 6-д** зааснаар 500 нэгж / 5,000 нэгж/
- “В” компани Компанийн тухай хуульд заасан ногдол ашиг тараахтай холбоотой үүргээ биелүүлээгүй тул **10.11 дүгээр зүйлийн 6-д** зааснаар 5,000 нэгж
- “Г” компани үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргээ биелүүлээгүй тул **Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 3-т** зааснаар 2,000 нэгж /20,000 нэгж/-тэй тэнцэх төгрөгөөр торгуулж байсан.



.....

**Мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах эрх зүйн орчинг тодорхой болгох:**

- Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах;



.....

**Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох:**

- ХК-уудын нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийн санг өргөжүүлэх;
- ТУЗ-ын гишүүдийн нэгдсэн мэдээлэл;



.....

**МХБ-ийн бүртгэлийг цэгцлэх ажлыг идэвхжүүлэх:**


- ТӨХК-уудыг олон нийтэд нээлттэй болгох;
- 100 хувь ТӨХК-уудыг хаалттай ХК хэлбэрт шилжүүлэх;
- Хэлбэрээ өөрчилж буй ХК-уудыг бүртгэлээс хасах асуудлыг шуурхай шийдвэрлэх;



.....

**Хорооноос хийх хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хяналтад шилжүүлэх:**


- Зайны хяналтын зарим чиг үүргийг МХБ-д шилжүүлэх асуудлыг судлах;



.....

**Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх:**

- ХК-уудын хувьцааны төвлөрлийг сааруулах чиглэлээр бодлогын арга хэмжээ авах;



.....

**ХЭХ-ыг хуралдуулахтай холбоотой зохицуулалтыг төгөлдөршүүлнэ.**

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА